

Э-Сонин

42 дахь дугаар



Мэдээний Тойм



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН АНХААРЛД

ЕВРАЗИ КАПИТАЛ ХОЛДИНГ НЭМЭЛТ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА ХИЙЛЭЭ



ОРОН НУТГИЙН ХУВЬЦААТ КОМПАНИУДАД ЗАЙНЫ СУРГАЛТ ЯВУУЛЛАА

"ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ" ХК-ИЙН 1072 ШИРХЭГ ХУВЬЦААНЫ 70 ХУВЬ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖЭЭР АРИЛЖААЛАГДАНА



"СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК" ХХК- ИЙН АРИЛЖААНД ОРОХ ЭРХИЙГ СЭРГЭЭЛЭЭ

НЭР БҮХИЙ ХК-ИЙН ҮНЭТ ЦААСЫГ МХБ-ИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА



НЭР БҮХИЙ ХК-ИУД КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ЗӨРЧСӨН ТУХАЙ СЗХ МЭДЭЭЛЛЭЭ



ТӨГСӨЛТИЙН БАЯР

СУРГАЛТ

“Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох” сургалт”-ыг 2016 оны 7 дугаар сарын 24-ны өдөр явуулахаар төлөвлөж байна.

ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

- Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдагууд хууль, журам, Монголын хөрөнгийн биржтэй байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарна уу.
- “Еврази капитал холдинг” ХК нэмэлт хувьцаа гаргах тухай танилцуулгаа үнэт цаасны компаниуд болон хөрөнгө оруулагч нарт хийлээ.
- Увс, Говь-Алтай, Хөвсгөл аймгуудад үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын эрх бүхий албан тушаалтнуудыг сургалтад хамруулан цахим хэлбэрээр явууллаа.
- “Сайн хувьцаа” арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор Засгийн газрын үнэт цаасыг 15 хүртэл жилийн хугацаатай, дотоодын зах зээлд үе шаттайгаар гаргана.
- Санхүүгийн зохицуулах хорооны 203 тоот тогтоолыг үндэслэн Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 238 тоот тушаалаар “Стандарт Инвестмент ҮЦК” ХХК-ийн арилжаанд орох эрхийг сэргээлээ

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 6-р сарын арилжааны мэдээ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН АНХААРАЛД

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдагууд хууль, журам, Монголын хөрөнгийн биржтэй байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарна уу.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд нь хууль журамд заасан үүргүүдийг биелүүлэн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, тухайн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг батлагдсан зааврын дагуу бэлтгэж, тогтоосон хугацаанд МХБ-д ирүүлэх ёстой боловч дараах нэр бүхий компаниуд мэдээллээ ирүүлээгүй байгаа тул гэрээнд заасан хариуцлагыг тооцох болсныг мэдэгдэж байна.

Цаашид бүртгэлтэй хувьцаат компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдагууд хууль, журам, Монголын хөрөнгийн биржтэй байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарна уу.

ЕВРАЗИ КАПИТАЛ ХОЛДИНГ НЭМЭЛТ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА ХИЙЛЭЭ

"Евразиа капитал холдинг" ХК нэмэлт хувьцаа гаргах тухай танилцуулгаа 2016 оны 6-р сарын 15 өдөр Монголын хөрөнгийн биржийн байранд Үнэт цаасны компаниуд болон хөрөнгө оруулагч нарт хийллээ.

Монголын Хөрөнгийн Биржийн гүйцэтгэх захирлын 2016 оны 05 сарын 19-ний өдрийн 197 тоот тушаалаар тус компанийн нэмж гаргаж байгаа нэг бүр нь 100 төгрөгийн үнэтэй 50.000.000 ширхэг хувьцааг бүртгэж, нийт хувьцааны тоог 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 52,270,892 ширхэг байхаар бүртгэлд өөрчлөлт оруулсан юм.



ОРОН НУТГИЙН ХУВЬЦААТ КОМПАНИУДАД ЗАЙНЫ СУРГАЛТ ЯВУУЛЛАА

Увс, Говь-Алтай, Хөвсгөл аймгуудад үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын эрх бүхий албан тушаалтнуудыг сургалтад хамруулан цахим хэлбэрээр явууллаа.

МХБ-д бүртгэлтэй орон нутаг дахь хувьцаат компаниудад “Мэдээллийн ил тод байдал” сэдвээр зайны сургалт, семинарыг 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтарч зохион байгууллаа. Сургалтыг баруун бүсийн Увс, Говь-Алтай, Хөвсгөл аймгуудад үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын эрх бүхий албан тушаалтнуудыг хамруулан цахим хэлбэрээр явуулж, хувьцаат компаниуд хууль, журамд заасан мэдээллээ олон нийтэд түргэн шуурхай хүргэх, МХБ-ийн цахим хуудаст мэдээлэл оруулах болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой хууль, журмуудыг дагаж мөрдөх талаар зөвлөгөө өглөө.

Хувьцаат компаниудын мэдээллийн ил тод байдлыг хангаснаар олон нийт болон хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн зах зээл дэх итгэл, хөрөнгө оруулагчдын сонирхлыг нэмэгдүүлэх, тэдэнд зөв сонголт хийх боломжийг олгох ач холбогдолтой юм.

"ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ" ХК-ИЙН 1072 ШИРХЭГ ХУВЬЦААНЫ 70 ХУВЬ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖЭЭР АРИЛЖААЛАГДАНА

Засгийн газрын ээлжит бус хуралдаан 6 дугаар сарын 16-нд болж, “Сайн хувьцаа” арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой зарим асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргасан байна. Үүнд:

“Сайн хувьцаа” арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор Засгийн газрын үнэт цаасыг 15 хүртэл жилийн хугацаатай, дотоодын зах зээлд үе шаттайгаар гаргаж, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн энгийн хувьцааны ногдол ашиг болон тус компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдсанаас олох орлогоос эргэн төлөх нөхцөлтэйгээр санхүүжүүлэн холбогдох гэрээ байгуулж ажиллахыг Сангийн сайд Б.Болорт даалгасан байна.

Мөн “Эрдэнэс Тавантолгой” компанийн өөрийн эзэмшлийн хувьцааг худалдах хүсэлт гаргасан Монгол Улсын иргэний эзэмшиж байгаа 1072 хүртэлх энгийн хувьцаанаас эхний ээлжинд 322 хувьцааг багцаар нь 300426 төгрөгөөр зохих журмын дагуу шууд, цаашид үлдэх хувьцааг Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан худалдан авахаар шийдвэрлэжээ.

“СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК” ХХК-ИЙН АРИЛЖААНД ОРОХ ЭРХИЙГ СЭРГЭЭЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны 203 тоот тогтоолыг үндэслэн Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 238 тоот тушаалаар “Стандарт Инвестмент ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2016 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн сэргээлээ.

НЭР БҮХИЙ ХК-ИЙН ҮНЭТ ЦААСЫГ МХБ-ИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА

Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 323 тоот, 2013 оны 277 тоот, 2014 оны 217 тоот, 2015 оны 256, 384, 404 тоот тогтоол болон Монголын хөрөнгийн биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журм"-ыг тус тус үндэслэн 2016 оны 6 дугаар сарын 22 өдөр дараах хувьцаат компанийн үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржийн бүртгэлээс хаслаа. Үүнд:

1. “Аэрогедези” (MSE:ARG) ХК-ийн **100** төгрөгийн нэрлэсэн үнэтэй **3,806,767** ширхэг хувьцаа
2. “Шинэчлэл-Инвест” (MSE:SCL) ХК-ийн **100** төгрөгийн нэрлэсэн үнэтэй **193,461** ширхэг хувьцаа
3. “Мон сав” (MSE:MSV) ХК-ийн **100** төгрөгийн нэрлэсэн үнэтэй **105,000** ширхэг хувьцаа
4. “Дорнод хүнс” (MSE:DHS) ХК-ийн **100** төгрөгийн нэрлэсэн үнэтэй **388,719** ширхэг хувьцаа
5. “Буудайн цацал” (MSE:CCA) ХК-ийн **100** төгрөгийн нэрлэсэн үнэтэй **72,076** ширхэг хувьцаа
6. “Ган тээрэм” (MSE:GTR) ХК-ийн **100** төгрөгийн нэрлэсэн үнэтэй **296,504** ширхэг хувьцаа

НЭР БҮХИЙ ХК-ИУД КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ЗӨРЧСӨН ТУХАЙ СЭХ МЭДЭЭЛЛЭЭ

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4-т заасны дагуу хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор буюу жил бүрийн 5 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө зарлан хуралдуулсан байх үүрэгтэй байдаг.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар тухайн компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх мэдээлэл, дүгнэлтийг хэлэлцэж баталдаг учир хувьцаа эзэмшигчдийн хувьд компанийхаа үйл ажиллагааны болон санхүүгийн байдал, үр ашгийн тухай мэдээлэл авах, мөн түүнчлэн компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагатай нүүр тулан уулзаж асуулт асууж хариулт авах замаар хувьцаа эзэмшигчийн нийтлэг эрхээ хэрэгжүүлдэг.

Дор дурдсан нэр бүхий 52 хувьцаат компаниуд 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуульд заасан хугацаанд зарлан хуралдуулаагүй байна.

1	“Авто импекс” ХК	21	“Дархан мах экспо” ХК	41	“Улаан сан” ХК
2	“Баянтолгой” ХК	22	“Дорнод” ХК	42	“Улиастай тэгш” ХК
3	“Завхан тээвэр” ХК	23	“Дөрвөн-уул” ХК	43	“Усжуулах” ХК
4	“Завхан тээх” ХК	24	“Еврофё азиа” ХК	44	“Хангал” ХК
5	“Чандмань дундговь” ХК	25	“Жинст” ХК	45	“Харгиа” ХК
6	“Авто зам” ХК	26	“Их нуур” ХК	46	“Харшийн гэгээ” ХК
7	“Агротех импекс” ХК	27	“Их үүсгэл” ХК	47	“Хөдөөгийн тээвэр” ХК
8	“Ажлын хувцас” ХК	28	“Мон-Асар” ХК	48	“Хуртай” ХК
9	“Алмаас” ХК	29	“Монгол дизель” ХК	49	“Цагаан толгой” ХК
10	“Арбаянхангай” ХК	30	“Монгол керамик” ХК	50	“Чандмань уул” ХК
11	“Ар тархи” ХК	31	“Монгол шевро ХК	51	“Эрдэнэт зандан” ХК
12	“Баялаг шарын гол” ХК	32	“Мөнх жим” ХК	52	“Эсгий гутал” ХК
13	“Баян талбай” ХК	33	“МүДИКС” ХК		
14	“Баян тоорой” ХК	34	“Оргил Говь-алтай” ХК		
15	“Бор нуур” ХК	35	“Өв усжуулагч” ХК		
16	“Бороогийн үйлдвэр” ХК	36	“Өргөн хэрэглээ” ХК		
17	“Бүтээл” ХК	37	“Сав шим” ХК		
18	“Гантөмөрт” ХК	38	“Сэлэнгэ импекс” ХК		
19	“Глобал монголиа холдингс” ХК	39	“Тав” ХК		
20	“Турилуvs” ХК	40	“Төв ус” ХК		

Иймд Компанийн тухай хуулийн 59.5-д зааснаар дээрх нэр бүхий хувьцаат компаниудын төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулахаас бусад бүрэн эрхгүй болсныг Санхүүгийн зохицуулах хорооноос үүгээр мэдээлж байна.

Компанийн тухай хуулийн 59.6-д зааснаар дээрх хувьцаат компаниудын ТУЗ-ийн бүрэн эрх нь дуусгавар болсон өдрөөс хойш байгуулсан гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр, бус болохыг тус компаниудын хувьцаа эзэмшигч, удирдлага, харилцагч байгууллага болон бусад холбогдох этгээдүүд анхаарна уу. Санхүүгийн зохицуулах хорооноос хувьцаат компаниудын засаглал, мэдээллийн болон санхүүгийн тайлагналын ил тод байдлыг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлд онцгой анхаарал хандуулан ажиллаж байгаа бөгөөд хууль тогтоомж зөрчсөн этгээдэд холбогдох хариуцлагыг хүлээлгэх болно.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ

ТӨГСӨЛТИЙН БАЯР



Монголын Хөрөнгийн Биржийн “Үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох” анхан шатны ээлжит сургалт 2016 оны 6 дугаар сарын 20-ноос 6 дугаар сарын 24-ны хооронд явагдаж дууслаа.

Сургалтыг онол-практикийг хослуулан Брокер, дилерийн компанийн үйл ажиллагаатай танилцуулах, арилжаанд оролцуулах хэлбэрээр явуулсан нь суралцагчдын сонирхолд ихэд нийцсэн сургалт боллоо.

Сургалтад цаашид хамрагдах сонирхолтой иргэд, оюутан залуусын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь нийгмийн эрэлт хэрэгцээ их байгаагийн илрэл юм. Иймд бид дараагийн сургалтыг 2016 оны 7 дугаар сарын 24-ны өдрөөс явуулахаар төлөвлөж байна.

Үнэт цаасны зах зээлийн боловсролоо дээшлүүлэх үйлсэд Тань амжилт хүсье





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

MONGOLIAN STOCK EXCHANGE

Вeб: www.mse.mn Утас: (976)-11-310456 Факс: (976)-11-325170 Email: trading_ml@mse.mn Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатарын талбай-2

САРЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

2016 оны 06 дугаар сар

Арилжааны товч мэдээ	
Арилжигдсан ширхэг	1,119,905
Нийт үнийн дүн /тeг/	524,465,545
Хэлцлийн тоо	1,321
Арилжигдсан үнэт цаасны тоо	53
Зах зээлийн үнэлгээ /тeг/	1,423,078,642,066

ТОП-20 индекс	
Хаалт	12,274.16
Өөрчлөлт /%/	11.15

MSE ALL индекс	
Хаалт	870.90
Өөрчлөлт /%/	11.35



Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:

Тоо ширхэгээр:				Үнийн дүнгээр:			
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	№	Симбол	Үнэт цаасны нэр	Үнийн дүн
1	SUU	СҮҮ	731,885	1	SUU	СҮҮ	126,585,986
2	APU	АПУ	150,537	2	APU	АПУ	111,536,065
3	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	78,500	3	TCK	ТАЛХ ЧИХЭР	37,785,290
4	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	52,653	4	GOV	ГОВЬ	32,963,915
5	UID	улсын их дэлгүүр	16,005	5	TTL	ТАВАН ТОЛГОЙ	19,833,235

Хамгийн их өсөлттэй үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					%
1	UYN	МОНГОЛ САВХИ	903.58		80.72
2	MIK	МИК ХОЛДИНГ	12,750.00		34.21
3	MCH	МОН.ЦАХИЛГААН ХОЛБОО	790.00		31.52
4	BUK	УБ БҮК	339.25		29.98
5	DHU	ДАРХАН ХҮНС	4,880.00		19.02

Хамгийн их бууралттай үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					%
1	BHG	БӨХӨГ	5,060.00		-27.71
2	ETR	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	77.00		-26.67
3	GTJ	ГУРИЛ ТЭЖЭЭЛ БУЛГАН	1,450.00		-25.64
4	IBA	ИХ БАРИЛГА	3,818.00		-15.16
5	BTG	БАЯНТЭЭГ	11,000.00		-12.07

Засгийн газрын үнэт цаас: /анхдагч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	Хугацаа /долоо хоног/	Хүүгийн хэмжээ %
1	-					
2	-					
3	-					

Засгийн газрын үнэт цаас: /хоёрдогч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Дээд ханш	Доод ханш	Сүүлчийн ханш
1	ZGEB-BD-12/05/18-A0033-16.875	10	1,055,000	105,500	105,500	105,500
2	ZGEB-BD-26/05/18-A0036-16.875	10	1,055,000	105,500	105,500	105,500
3	ZGEB-BL-25/07/16-A0094-0	49	4,846,100	98,900	98,900	98,900
4	ZGEB-BL-15/11/16-A0075-0	45	4,287,150	95,270	95,270	95,270
5	ZGEB-BL-15/11/16-A0075-0	533	50,794,900	95,300	95,300	95,300